



НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫГ НЭМЖ
БАТАЛСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУД ХУГАЦААНДАА
ХЭРЭГЖИХГҮЙ ОН ДАМЖИН ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ БҮРДЖЭЭ

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД:ХОА-2025/06-20-ШТА-НА

Ховд хот
2025 оны 05 сар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Нарандэлгэр
Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Цахим хаяг: Munkhtulgad@audit.gov.mn
Аудитор: Ц.Азаяа Цахим хаяг: azzayats@audit.gov.mn
Аудитор: Н.Батжаргал Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn
Аудитор: Д.Нямгарав Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn
Аудитор: Д.Энхжаргал Цахим хаяг: enkhjargal@audit.gov.mn
Аудитор: Н.Ариунтуяа Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn
Аудитор: Н.Батзул Цахим хаяг: Batzuln@audit.gov.mn
Аудитор: Т.Бат-Эрдэнэ Цахим хаяг: baterdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитын хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Нийслэл дэх ТАГ, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилгыг чиглүүлж, аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх. • Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагч, ХОХБТХ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумдын Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулж горим сорилыг хэрэгжүүлсэн болно.
Аудитын хязгаарлалт	Аудитын явцад хөрөнгө оруулалтын ажлуудад ХБТХОХ, ГХБХБГ-уудын ажил хариуцсан мэргэжилтнүүд хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлсэн тайлан, тоон мэдээлэл иж бүрэн бус, архивын нэгж үүсгээгүй, ажил хариуцсан албан хаагч солигдсон, зарим төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжээс санал тайлбар авахад бэрхшээл үүссэн зэрэг асуудлууд аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор А.Нарандэлгэр, Д.Мөнхтулга, аудитор Ц.Аззаяа, Н.Батжаргал, Т.Бат-Эрдэнэ, Д.Энхжаргал, Д.Нямгарав, Н.Батзул, Н.Ариунтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитыг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудиттай хамт эхэлж 2025 оны 05 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, шалгагдагч байгууллагуудаас санал авч, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан, Нийслэлийн ТАГ болон аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аймгийн ИТХ-ын XIV хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 14/04 дүгээр тогтоолоор аймгийн ТЭЗ-ын 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг баталж 59 төсөл арга хэмжээнд 11,466.2 сая төгрөгийн зарцуулахаар анх баталсан байна.

Улмаар аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн XVIII хуралдааны 18/03 дугаар тогтоолоор 78 төсөл арга хэмжээнд 10,587.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн 306.2 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг хасан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 83 төсөл арга хэмжээнд 11,553.1 сая, замын сангаас 13 төсөл арга хэмжээнд 1,971.6 сая, байгаль хамгаалах сангаас 14 төсөл арга хэмжээнд 980.6 сая, агаарын бохирдлыг бууруулахад 2 төсөл, арга хэмжээнд 2,604.5 сая, их засварт 25 төсөл, арга хэмжээнд 4,637.3 сая төгрөгийн эх үүсвэрийг тодотгон баталжээ. Аймгийн ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын жагсаалтаар авч үзвэл:

- *ОНХО-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлын эх үүсвэрийг 3,646.4 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1 төсөл арга хэмжээний 166.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 2 төсөл арга хэмжээний 140.2 сая төгрөг нийт 306.2 сая төгрөг хасаж, 2024 онд шинээр хэрэгжүүлэх 83 төсөл арга хэмжээнд 8,212.9 сая төгрөгийг нэмэлтээр тодотгож нийт 11,553.1 сая төгрөгийг зарцуулахаар баталсан,*
- *Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих их засварт 3,555.6 сая төгрөгийн их засварын ажил батлагдсан, төсвийн тодотголоор 6 төсөл арга хэмжээний төсөвт өртөг дээр 1,081.7 сая төгрөг нэмж нийт 25 төсөл арга хэмжээнд 4,637.3 сая төгрөгийг зарцуулахаар баталсан,*
- *Замын санд шилжих хөрөнгө оруулалтыг 61.2 сая, шинээр эхлэх хөрөнгө оруулалтыг 1,026.6 сая, төсөл, арга хэмжээг 50.0 сая, урд оны үлдэгдлээс 441.3 сая төгрөгийг оруулахаар санхүүгийн эх үүсвэрийг нийт 1,579.1 сая төгрөгөөр баталж 392.5 сая төгрөгийг нэмж тодотгон, 2024 онд шинээр хэрэгжүүлэх болон өмнөх оноос дамжсан 13 төсөл, арга хэмжээнд 1,971.6 сая төгрөг зарцуулахаар баталсан*
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 80.6 сая төгрөг батлагдсан бөгөөд тодотголоор 14 арга хэмжээ болгон өөрчилж 980.6 сая төгрөгийг зарцуулахаар баталсан,
- Агаар орчны бохирдлыг бууруулах хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээний 2 ажилд 2,604.5 сая төгрөг тус тус төлөвлөсөн байна.

Аймгийн 17 сумаас Жаргалант, Цэцэг сумууд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг тухайн шатны ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн байна. Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 09 сарын 13-ны XV дугаар хуралдаанаар 2,539.0 сая төгрөгийн өртөгтэй 69 төсөл арга хэмжээнд 2,338.5 сая төгрөгийг 2024 онд санхүүжүүлэхээр, Цэцэг сумын ИТХ-ын 15 дугаар хуралдаанаар 522.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээнд 522.2 сая төгрөгийг 2024 онд хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

Тайлант онд 40,556.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 230 багц ажил төлөвлөснөөс 39,331.4 төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ажлын 26,343.1 сая төгрөгийн дүнтэй гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан байна.

Орон нутгийн төсийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 230 ажлын 64 хувь буюу 148 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан, 12 хувь буюу 28 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу, 23 хувь 54 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АРГАЧЛАЛЫН ДАГУУ ҮНЭЛЖ ЭРЭМБЭЛЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

Ховд аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн, төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглахтай холбоотой зардлын тооцоололгүй төлөвлөсөн байна

1.1.1 Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд уялдуулан аймгийн ИТХ-аас Ховд аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг 2023 оны 13/03 дугаарын тогтоолоор баталсан.

1.1.2 Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Ховд аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй 1,370.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусган баталсан нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4¹-т заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- *Хуучин 1 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар (Жаргалант сум)*
- *Нийтийн үйлчилгээний байгууллагуудын ажилчдын ажлын байрны тохижилт*
- *Байрны тохижилт (Гадаадын иргэн харьяатын газар)*
- *Тавилга, тоног төхөөрөмж (Орон нутгийн өмчийн газар)*
- *Авто машин, тавилга, тоног төхөөрөмжийн дэмжлэг (Татварын хэлтэс)*
- *Тавилга, тоног төхөөрөмж (Худалдан авах ажиллагааны газар)*
- *Аймгийн ЗДТГ-ын автомашины шинэчлэл*
- *Авто машин (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв)*
- *Компьютер, тоног төхөөрөмж (ГИХГ)*
- *Барилгын засвар, тохижилт (Тагнуул)*
- *Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардал /МУЗЗНДНТУТХ 44.2/*
- *Шүүхийн шийдвэрийн өр /"Мянган Угалзат" ОНӨААТҮГ/*
- *Аймгийн 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын ажиллагааны шатахууны зардал*
- *Ховд хотын цэцэрлэгүүдийн түүхэн номын санхүүжилт*
- *2023 онд үерт өртсөн айл өрхийн нөхөн олговрын санхүүжилт (Жаргалант сум)*
- *Гамшгийн нөөц бүрдүүлэх (Улаан загалмай)*

1.1.3. Жаргалант сумын Бичигт багт баригдаж байгаа цэцэрлэгийн барилгын гадна зогсоол, тоглоомын талбай газар чөлөөлөх ажилд 50.0 сая төгрөг зарцуулахдаа газрын байршлыг оновчгүй төлөвлөсөн, цаашид газрыг ашиглахад орон зайн хувьд хязгаарлагдмал байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

1.1.4. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан дараах төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглахтай холбоотой зардлын тооцооллыг хийгээгүй төлөвлөсөн байна.

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Хөрөнгийн ашиглалтын зардлыг тооцоо хийсэн эсэх	
					Урсгал зардал	Орон тоо
1	Камержуулалт /Ногоон бүс/ 1	2023	2024	1,534.2	Үгүй	Үгүй
2	Цахилгаан шат хийх санхүүжилт (Бүсийн оношилгоо, эмчилгээний төв)	2024	2024	230.4	Үгүй	
3	Хатуу хөтлийн суурин газрын зүүн талд инженерийн хийцтэй худаг (Жаргалант сум, Цамбагарав баг)	2024	2024	40.0	Үгүй	Үгүй

¹ орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

4	Өрхийн эмнэлэгийн барилгын өргөтгөл (Жаргалант ӨЭМТ)	2024	2025	80.0	Үгүй	Үгүй
5	12 авто машины граш (Зэвсэгт хүчний 123 дугаар анги)	2024	2024	100.2	Үгүй	
6	Камержуулалт /Ногоон бүс/ 2	2023	2024	1,534.2	Үгүй	
7	Хотын нийтийн бие засах газар байгуулах /CITY toilet, тамхины цэг/	2023	2024	253.5	Үгүй	Үгүй
8	Ховд хотын гэрэлтүүлэг (Жаргалант сум)	2023	2024	512.0	Үгүй	
Нийт				4,284.5		

Эх сурвалж: ОНХО-ын судалгаа

1.1.5.Тухайн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг батлахдаа Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд үндэслэн, хөрөнгө ашиглахтай холбоотой зардлын тооцооллыг бүрэн хийж төлөвлөх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгасан байна

1.2.1 2024 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 36,621.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 137 төсөл арга хэмжээний 21,747.1 сая төгрөгийн төсвийг баталжээ. Үүнийг эх үүсвэрээр нь ангилан харуулбал:

1.2.2 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг тодотголоор 10,587.1 сая төгрөгөөр нэмж баталсан нь ААНОАТ-ын орлогын гүйцэтгэл давж биелсэнтэй холбоотой байна.

1.2.3 Дээрх баталсан төсөл арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлээгүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.1² -т заасантай нийцэхгүй байна.

1.2.4 Жаргалант сум орон нутгийн төсвийн 2024 хөрөнгө оруулалтаар 2,539.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 69 төсөл арга хэмжээний 2,338.5 сая төгрөгийн , Цэцэг сум 551.7 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээний 551.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв тус тус баталжээ

- Жаргалант сумын Засаг дарга нь 2024 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг 2024 оны 09 дүгээр сарын 13- ны өдөр тодотголоор баталсан нь төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжихгүй байх, гэрээг үндэслэлгүй сунгах, ХАА-ааг зохион байгуулахад хүндрэл үүсгэсэн,
- Цэцэг сумын Засаг дарга нь төсөв батлах тогтоолын төсөл боловсруулахдаа бүрэн бус, төсөвт өртөгийн дүнг зөрүүтэй тусгасан, төсөвлөлтийн шаардлага хангаагүй багийн төвийн барилга барих 3 төсөл арга хэмжээг төлөвлөсөн,

1.2.5 Хөрөнгө оруулалтын ажлын төсөв хийсэн төсөвчин нь хяналтын төсөв, гүйцэтгэлийн төсвийг зэрэг хийсэн, хамаарал бүхий компани нь хяналтын төсвийг хийсэн ажлын гүйцэтгэгчээр шалгарч ажлыг гүйцэтгэсэн, зарим төсвийг алдаатай хийсэн зэрэг зөрчил нь БХБС-ын 2016 оны 103 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Барилгын төсөвчний ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн зөрчилд албан шаардлага өглөө.

1.2.6 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй, магадлалын дүгнэлтээр баталгаажгаагүй, газрын зөвшөөрөлгүй 12,687.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл арга

² Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

хэмжээг төлөвлөсөн, төсөв батлагдсаны дараа зураг төсвийг боловсруулж байгаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³-д заасныг зөрчсөн байна. Хавсралт-1

1.2.7 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаа нь батлагдсан төсөвт тааруулан ажлын тоо хэмжээг багасгах, барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, тохижилтын ажил иж бүрэн хийгдэхгүй орхигдох, төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх зэрэг асуудлын суурь шалтгаан болж байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зарим төсөл арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна

1.3.1 Ховд аймагт орон нутгийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 28, тухайн оноос эхлэн хэрэгжих 190, нийт 40,556.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 218 төсөл, арга хэмжээг 24,294.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

1.3.2 Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 10 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгасан байна.

1.3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй, төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг тэнцүү хуваарилах байдлаар тооцож батлаагүй 7,119.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 2,768.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөн баталсан байна.

1.3.4 Эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн засвар /Жаргалант сум/-ны ажлын даалгаварт тусгасан тоо хэмжээнээс цэвэр ус, бохир усны шугам, дулааны узель шинээр зангидаж угсарч монтажлах, хэрэглээний халуун усны шугам шинээр угсарч монтажлах, 00 тоноглол шинээр хийх ажлуудыг орхигдуулсан, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан төсөвт өртгийг 301.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн гэрээний дүнг 738.8 сая төгрөг болгосон ч батлагдсан зураг төсөвгүйгээр гүйцэтгүүлж, хүлээн авсан зөрчил илэрлээ.

1.3.5 Дарви суманд хийгдэж байгаа "Сумын хөгжил-дэд бүтэц, төвийн нэгдсэн цэвэр бохир усны гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил", "Сумын хөгжил-дэд бүтэц, төвийн нэгдсэн цэвэр бохир ус, эх үүсвэрийн цахилгаан, төв магистрал дулаан, цэвэр, бохир шугам сүлжээний ажил" ТАХ нь ажилд дараах зөрчил илэрлээ. Үүнд.

- 2.1 тэрбум төгрөгийн төсвийг хувааж, дахин төсөв хийлгэхдээ Цэвэр ус дамжуулах шугамын ажил 204.2 сая, 10 кв-ын ЦДАШ-ын ажил 136.5 сая төгрөгөөр тус тус анхны төсвөөс зөрүүтэй төсөвлөгдсөн,
- Зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүй,
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 1 дүгээр багцыг зураг төсөвтэй, 2 дугаар багц ажлыг ажлын тоо хэмжээгээр зарласан,
- барилгын ажлын зөвшөөрөл олгогдоогүй байхад Бүтээмж тауэр ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн,

1.3.6 Хөрөнгө оруулалтын ажлуудын тухайн жилийн санхүүжих дүнг оновчтой бус, ажлын тоо хэмжээг дутуу тусган төлөвлөж байгаа нь ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, он дамжин олон жил үргэлжлэх, хүрэх үр дүнг бууруулах эрсдэлийг дагуулж байна.

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫГ НЭМЖ БАТАЛСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУД ХУГАЦААНДАА ХЭРЭГЖИХГҮЙ ОН ДАМЖИН ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ БҮРДЖЭЭ

Хууль тогтоомжийг зөрчин аймгийн онцгой комиссын шийдвэр гарган зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын аргыг баримлахгүйгээр гэрээ шууд байгуулжээ

2.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 192 төсөл арга хэмжээнээс төсөвт өртөгт үндэслэн 17,503.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 3,940.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 7,662.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 89 төсөл арга хэмжээг ШХА-ын аргаар тус тус зарласан, 4,897.8 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүйтэй холбоотой худалдан авах ажиллагааг зарлаагүй байна.

2.1.2 Гэвч тендер шалгаруулалтын аргыг буруу сонгож, худалдан авах ажиллагааг зарласан нь Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоосонтой нийцэхгүй байна.

Үүнд:

Харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй ТАХ:

- Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар батлагдсан Нийтийн эзэмшлийн орон сууц, гудамж, зам талбайн нөхөөс, хайс тоноглолын засвар арчлалтын ажилд батлагдсан төсөл арга хэмжээнээс Авто замын засвар, нөхөөс хийх 47.6 сая төгрөгийг төсөвт өртөгтэй ажлыг шууд гэрээ байгуулсан,
- "Сити такси" ХХК-ийн байрнаас ЕБ-ын 6 дугаар сургууль чиглэлийн шугам 800 метр ф-100 шугам (Жаргалант сум)
- Жаргалан сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Баатар хайрхан ӨЭМТ-н граш, зорилтот бүлгийн иргэдийн хөгжил хамгаалал төсөл арга хэмжээний ХАА-г хуулийн дагуу зохион байгуулаагүй,

2.1.3 Аймгийн онцгой комиссын шийдвэр гарган зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын аргыг баримтлахгүйгээр гэрээ шууд байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1⁴, 35.1.2⁵-д заасантай тус тус нийцэхгүй байна. Үүнд:

Хүснэгт 4: ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг уялдаагүй төлөвлөсөн

сая.төг

Д/д	Төсөл хөтөлбөр ажлын нэр	Мөнгөн дүн
1	Малчны хорооллын 8, 9,10, 11 дүгээр гудамжны цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил (Жаргалант сум, Цамбагарав баг)	249.5
2	Магсаржав баг КТПН-168 дэд станц (Ховд цахилгаан түгээх сүлжээ)	149.3
3	Их гүүр дээд талын суурьшлын 12,13,14,15,16 дугаар гудамжны цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил (Жаргалант сум, Цамбагарав баг 19 дүгээр гудамж)	347.5
4	Цэвэр усны 400 метр ф-150 шугам шинэчлэх (Жаргалант сум, Цамбагарав баг)	167.3
5	Монгол банк чиглэлийн 85 метр ф-100 шугамыг шинэчлэх (Жаргалант сум, Цамбагарав баг),	15.2
6	"Сити такси" ХХК-ийн байрнаас ЕБ-ын 6 дугаар сургууль чиглэлийн шугам 800 метр ф-100 шугам (Жаргалант сум)	96.3
7	Магистрал шугамын Наран баг дахь өрхийн эмнэлгийн цэвэр усны шугамын засвар	50.00
8	ЕБС-ийн барилгын сантехникийн засвар (Үенч сум)	60.87
	Нийт дүн	1,136.0

⁴ захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

⁵ онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

2.1.4.Захиалагч тендер зарлахаас зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.3⁶-д заасныг зөрчсөн байна.

- Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар батлагдсан Нийтийн эзэмшлийн орон сууц, гудамж, зам талбайн нөхөөс, хайс тоноглолын засвар арчлалтын ажилд батлагдсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хуваан "Арван мянгатын уулзвар-Дарви өргөө барилгын уулзвар хүртэлх авто замын бордюрыг шинээр солих, 19.5 сая, "Арван мянгатын уулзвар-Хуучин нисэхийн уулзвар хүртэлх авто замын бордюрыг авах, зөөж тээвэрлэх, шинээр хийсэн авто замын бордюрыг будах" ажлыг 19.6 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан.

2.1.5.Батлагдсан хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч зарим хөрөнгө оруулалтын ажлуудад оролцогч ирээгүйгээс 4-7 удаа зарлаж, гүйцэтгэгч сонгон шалгараагүй байгаа тул тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж үр дүнтэй ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Жаргалант сумын автобусны зогсоол 2 ширхэг/Тахилт баг/- 4 удаа тендер зарласан боловч гүйцэтгэгч ороогүй
- Цэцэг сумын багийн төвийн барилга /Баянгол баг/, багийн төвийн барилга /Баян овоо баг/-ТАХ-үүдийг тус бүр 7 удаа зарласан ч гүйцэтгэгч ороогүй,

2.1.6.Тендерийн баримт бичигт өмнөх ажлын гүйцэтгэл шаардсан эсэхийг түүвэрчлэн хянахад 1 компанид хэд хэдэн ажил өгөх, хэд хэдэн багцад 1 компани зэрэг шалгаруулснаар хөрөнгө оруулалтын ажлууд хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна. Тухайлбал:

- Ивэнгийн шугуй ХХК нь Жаргалант сумын ОНХО-аар хийгдсэн 3 ТАХ-нд гүйцэтгэгч шалгарсан ч 1 ажлын хэрэгжилт дутуу, 1 ажлыг огт хийгээгүй,
- 2 дугаар сургуулийн дотоод орчин, ангиудыг камержуулах ажилд 2 компани үнийн санал ирүүлсэн ба хамгийн бага үнийн саналтай, шаардлага хангаж байгаа материал ирүүлсэн аж ахуйн нэгжийг шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын баримт бичиг дутуу ,
- Тендерийн баримт бичигт заасан өмнөх оны болон энэ оны ажлын гүйцэтгэл 90 хувьд хүрээгүй тохиолдолд уг тендерээс татгалзана гэсэн шаардлагыг хангаагүй компанийг шалгаруулсан. Үүнд: Сумын хөгжил-дэд бүтэц, Төвийн нэгдсэн цэвэр, бохир ус, эх үүсвэрийн цахилгаан, төв магистрал дулаан цэвэр, бохир шугам сүлжээний ажил (Дарви сум)

2.1.7. Жаргалант сумын ОНХО-аар хэрэгжүүлсэн 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний гүйцэтгэлийн баталгааг хангуулаагүй гэрээ байгуулсан, салбарын онцлог, нийгэм, эдийн засгийн байдал, ижил төстэй ажлуудын зарласан тендерийн баримт бичгийг харгалзан үзээгүй байна.

2.1.8. Иймд тендерийн баримт бичиг боловсруулах нэг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж, үр дүнтэй зохион байгуулах талаар үнэлгээний хороог мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын ажлуудад тавих үе шатны хяналт сулаас аймаг, сумдын ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 64 хувьтай байна

2.2.1 Тайлант онд 40,556.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 230 багц ажил төлөвлөснөөс 39,331.4 төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ажлын 26,343.1 сая төгрөгийн дүнтэй гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан байна.

2.2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 219 төсөл арга хэмжээнээс 203 төсөл арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар, 16 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөн баталжээ.

⁶ "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"

2.2.3 Аймгийн хэмжээнд нийт 230 багц ажлаас 64 хувь буюу 148 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 12 хувь буюу 28 багц төсөл арга хэмжээ дутуу хэрэгжиж, 24 хувь буюу 54 багц төсөл арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй байна. Хэрэгжиж эхлээгүй 54 төсөл арга хэмжээнээс 12 ажилд 4,183.7 сая төгрөгийн гэрээг байгуулсан бол 42 ТАХ-ний гэрээг байгуулаагүй байна.

2.2.4 Тайлант онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 6,888.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 28 төсөл арга хэмжээний хэрэгжилт өвлийн улирал эхэлсэн, зураг төсөвт өөрчлөлт оруулсан, гүйцэтгэгч гэрээний үүргийн биелэлтийг хугацаандаа хэрэгжүүлээгүй зэргээс шалтгаалан дутуу хэрэгжилтэй байна.

2.2.5 Мөн оны эцэст тодотгол хийгдэж, худалдан авах ажиллагааг зарласнаар төлөвлөсөн арга хэмжээг тайлант ондоо хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн байна.

2.2.6 Хугацаандаа хэрэгжиж дуусаагүй, хэрэгжээгүй төсөл арга хэмжээнүүд нь гэрээг оройтож байгуулсан, ажлыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгээгүй зэрэг шалтгаануудаас төсөл арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, захиалагч гэрээг дүгнээгүй, хэрэгжилтийг хангах ажлын зохион байгуулж ажиллаагүйгээс шалтгаалсан байна.


2.2.7. Захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, худалдан авах гэрээг 1-3 удаа сунгахдаа гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг хэрхэн үнэлж гэрээг сунгасан талаарх нотлох баримт хангалтгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын гэрээг сунгаж, 2025 онд хүлээлгэн өгөхөөр байгуулсан нь холбогдох гэрээнд заасан “Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон бол алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна” гэсэн заалттай нийцээгүй байна.

2.2.8. Аймаг, сумдын ОНХО-аар хэрэгжих ТАХ-ны тоо, төсөвт өртөг нэмэгдэж, төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад хүлээн авснаар иргэд, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, төрийн үйлчилгээг хүргэх ая тухай нөхцөл бүрдэж байна. Тухайлбал:

- Хатуу хөтлийн суурин газрын өндөр хүчдэлийн трансформатор (Жаргалант сум, Цамбагараг баг 7-р гудамж) 72.9 сая төгрөгөөр Тото лайтинг сервис ХХК 2 трансформаторыг суурилуулж хүлээлгэн өгснөөр шинэ суурьшлын бүсийн айл өрхүүд цахилгаанаар хангагдаж бүрэн боломжтой болсон,
- Малчны хорооллын 8, 9, 10, 11 дүгээр гудамжны цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил (Жаргалант сум, Цамбагараг баг) 249.5 сая төгрөгөөр Тото лайтинг сервис ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгснөөр малчны хорооллын айл өрхүүд цахилгаанаар хангагдаж бүрэн боломжтой болсон,
- ЕБС-ийн их засвар /Дөргөн сум/ 234.0 сая төгрөгөөр Буянт ундрах шим ХХК сургуулийн гадна болон дотор засварын ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгснөөр хүүхдүүдийн сурч боловсрох таатай орчин бүрдсэн,
- Хаш дайчин ХХК гүйцэтгэж байгаа Наран багийн орон сууцны нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт /Буянтын боргио / ажил хэрэгжсэнээр тэр орчны 136 айлын оршин суугчид, хүүхэд хөгшдийн ая тух хангагдсан, зорчих хөдөлгөөн аюулгүй болсон,



- Мөнх энэрэлт үйлс ХХК-н гүйцэтгэсэн 59.3 сая төгрөгийн өртөгтэй 15 дугаар цэцэрлэг хүүхдийн тоглоомын талбайн тохижилт, авто зогсоолын ажил нь цаг хугацаа давчуу, хүйтний улиралд гүйцэтгэсэн гэхэд чанар, гүйцэтгэл сайн, ашиглагч тал болон эцэг эхчүүдийн сэтгэлд нийцсэн,
- Ди Эй СААН бюлдинг ХХК 67.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Барилгын засвар /Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэг/ ажил нь зураг, төсвийн дагуу чанартай сайн гүйцэтгэж хүүхэд сурч хөгжих тухай орчин бүрдсэн,
- Талын таван бүргэд ХХК 143.4 сая төгрөгөөр нийлүүлсэн Авто машин /Цагдаагийн газар/ нь Төрийн тусгай албан хаагчдыг иргэд олон нийтэд цаг алдалгүй хүрч үйлчлэх боломж бололцоог хангасан,
- Хаш дайчин ХХК-ны гүйцэтгэсэн 258.3 сая төгрөгийн өртөгтэй Жаргалант ЕБ 1-р сургуулийн биеийн тамирын заалны засварын ажил чанар стандарт хангасан сайн ажил болсон.
- ЕБС-ийн 16 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 15 цэцэрлэгт 31.3 сая төгрөгийн өртөг бүхий 100 литр багтаамжтай 43 ширхэг ус халаагч бойлуур суурилуулах төсөл арга хэмжээ амжилттай хэрэгжиж, дотуур байрны хүүхдүүд болон цэцэрлэгийн хүүхдүүдийн хэрэгцээнд өдөр тутам хэрэглэж байгаа нь ач холбогдолтой ажил болсон байна.



2.2.9 Тайлант онд хугацаандаа бүрэн хэрэгжсэн 15,270.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 148 төсөл арга хэмжээнээс шинээр хэрэгжих 121, шилжин хэрэгжих 27 төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

2.2.10 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжийг хүлээн авахдаа ажлын тоо хэмжээ дутуу, зураг төсвийн дагуу бүрэн хийгээгүй ТАХ болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй байхад комисс хүлээн авсан зөрчил нийтлэг байна.

2.2.11 Дээрх зөрчлүүд нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, гэрээнд заасны дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан зөрчилт албан шаардлага хүргүүлэв.

2.2.12 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хугацаандаа хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, гэрээг дүгнэн үргэлжлүүлэн санхүүжүүлэх, эсвэл цуцалж хариуцлага тооцох зэргээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай санхүүжилтийг ирэх онуудын төсөвт тусгах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ОЛГОСОН Ч ХҮЛЭЭН АВСАН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛД БҮРЭН ТУСГААГҮЙ БАЙНА

Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй, төлөвлөсөн ажлын 36 хувь нь бүрэн хэрэгжээгүй байна

3.1.1. Тайлант онд 40,556.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 230 багц ажил төлөвлөснөөс 39,331.4 төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ажлын 26,343.1 сая төгрөгийн дүнтэй гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан байна Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймаг, сумдаар харуулбал:
"График 2:ОНХО-ын хэрэгжилтийн судалгаа



3.1.2 Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянахад Замын сан 80 хувьтай, ОНХО, их засварын хэрэгжилт 62 хувьтай, БХС 56 хувьтай, агаар орчныг бохирдлыг бууруулах сан 50 хувийн хэрэгжилттэй байгаа тул цаашид салбар хариуцсан албан тушаалтнууд хариуцсан салбарын хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

3.1.3 Нийт санхүүжүүлсэн зардлаас 16,402.5 сая төгрөгийн санхүүжилт, 19.6 сая төгрөгийн магадлалгүй ажлын зардлыг гэрээ байгуулсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгож, чанарын хяналтын баталгааны 879.1 сая, зохиогчийн хяналт болон зургийн үнийн 69.9 сая төгрөг, гэрээний хугацаа хэтрүүлсэн алдангийн 0.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд, захиалагчийн хяналтын 185.4 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд тус тус суутган байршуулжээ.

3.1.4 2023 оноос хэрэгжиж эхэлсэн Хотын нийтийн бие засах газар байгуулах /CITY toilet, тамхины цэг/, Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил, Сумдын нэгдсэн цэвэр усны шугам сүлжээний ажлын дэмжлэг /Дуут, Чандмань, Дарви сум/, Буянт голын Жанжин боолтын засварууд зэрэг ажлууд нь дуусаагүй 3 дахь жилдээ он дамжиж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5 -д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" заалттай нийцэхгүй байна.

3.1.5 Жаргалант сум, Цэцэг сумууд төлөвлөсөн ТАХ-ний гэрээ байгуулахдаа барьцаа хөрөнгийг суутгах талаар заалт оруулаагүйгээс барьцаа суутган авахгүй байгаа нь хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих хөшүүргийг захиалагч байгууллагаас хэрэгжүүлэхгүй байгаа нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 4.2.2.6⁷-д заасан заалтыг зөрчиж байгаа тул албан шаардлага өглөө.

3.1.6 Аймгийн ОНХО данснаас Биеийн тамирын талбайн тохижилт, засвар (Жаргалант сумын ЕБС-ын 1 дүгээр сургууль) гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслээгүй байна.

3.1.7 Аймгийн Засаг дарга нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийх хөрөнгө оруулалтын ажлын гэрээнд тусгах урьдчилгаа олгох жишиг хувь хэмжээг тогтоосон А/146

⁷ чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх

дугаар захирамжийг 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр гаргаж, ОНХО -ын 10 төсөл арга хэмжээнд 378.5 сая төгрөг, Жаргалант сумын ОНХО -ын 21 төсөл арга хэмжээнд 1,547.7 сая төгрөг, Цэцэг сумын ОНХО-ын , 1 төсөл арга хэмжээнд 85.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг баталгаа гаргаагүй гүйцэтгэгчид олгосон, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэхгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 43 дугаар зүйлийн 43.3⁸-т заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

3.1.8 Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрхгүй мэргэжлийн бус иргэнийг аймгийн Засаг даргын захирамжаар эрх бүхий төлөөлөгчөөр томилж, хүүхдийн ордны барилгын их засварын ажилд хяналт хэрэгжүүлэх зардал олгосон нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралт "барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 2.5⁹ , Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2¹⁰-т заасан заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.9. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа хүлээн авах комисс, төрийн албан хаагчид төсөл арга хэмжээний үе шатуудад хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлан, хурлын тэмдэглэл байхгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна

3.2.1 Аймаг, сумдын ОНХО-аар хэрэгжих 22,159.5 сая төгрөгийн 186 төсөл, арга хэмжээнд 17,562.1 сая төгрөгийн санхүүжилтийг аймаг, сумдын төрийн сангаас хяналт хэрэгжүүлэн олгожээ.

3.2.2 Тайлант онд хэрэгжиж дууссан 7,579,6 сая төгрөгийн 70 ТАХ-г төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын дансанд холбогдох шийдвэрийн дагуу бүрэн бүртгэсэн байна.

3.2.3 Харин комисс ажиллаж хүлээн авсан 9 ТАХ-ний 3,723.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах шийдвэр гараагүйгээс бүртгэлд тусгаагүй нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын 2.3.1.10¹¹ заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.2.4 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилгыг улсын комисс зураг төсвийн дагуу хүлээн аваагүйгээс 2024 оны Жаргалант сумын ОНХО-аар Домбот хотхоны хүүхдийн тоглоомын талбай /Буянт баг/, хүүхдийн тоглоомын талбай, гадна орчны тохижилт /цэнгэг хотхон-Тоск 120 айл / , Наран багийн орон сууцны нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт /Буянтын боргио / зэрэг 580.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь төсвийн үр ашгийг бууруулж байна.

3.2.5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оны аудитаар өгөгдсөн 129.8 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 3,724.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 255.6 сая төгрөгийн 4 зөвлөмж, 115.5 сая төгрөгийн 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр нийт 4,224.9 сая төгрөгийн зөрчилд аудитын шийдвэр гаргаж хүргүүлснээс хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

3.2.6 Шийдвэрийн хэрэгжилт 54.0 хувьтай байгаа бөгөөд ТЕЗ нь төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийг бүрэн биелүүлээгүй, шийдвэрийн хэрэгжилтийн хангах ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй, удирдлага арга зүйгээр хангаж, хяналт

⁸ Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.

⁹ Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээд нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага, туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.

¹⁰ Барилга захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, эсхүл холбогдох чиглэлээр бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг сонгон ажиллуулж болно

¹¹ төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх

хэрэгжүүлээгүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нийт 15,200.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 254.7 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 4,243.3 сая төгрөгийн 12 зөрчил арилгуулах албан шаардлага, 1,145.2 сая төгрөгийн сахилгын хариуцлага тооцуулах 3 албан шаардлага тогтоон, 9,322.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 14 зөвлөмж өгөгдлөө.

Ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй 235.3 сая төгрөгийн 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар МУЕА-т уламжлав.

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Ховд аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн, төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглахтай холбоотой зардлын тооцоололгүй төлөвлөсөн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгаснаар зөрчлийн тоо буурахгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зарим төсөл арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна.
- Хууль тогтоомжийг зөрчин аймгийн онцгой комиссын шийдвэр гарган зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын аргыг баримлахгүйгээр гэрээ шууд байгуулсан байна.
- Хөрөнгө оруулалтын ажлуудад тавих үе шатны хяналт сулаас аймаг, сумдын ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 64 хувьтай байна.
- Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй, төлөвлөсөн ажлын 36 хувь нь бүрэн хэрэгжээгүй байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Нийцлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Эрхбаяр танаа

- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг батлах.

Аймгийн Засаг дарга М.Амарсанаа танаа

- ✓ Зураг төсөвгүй, магадлалаар баталгаажуулаагүй барилга байгууламж, төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх
- ✓ Орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудад тавих захиалагчийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэн, хяналт хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй этгээдээр хяналтыг гүйцэтгүүлэх.

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анхбаяр танаа

- ✓ Төсөл арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгуулахаар хүргүүлэхдээ хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэн хөрөнгө оруулалтын жагсаалт гарган Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
- ✓ Ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, ажлын тоо хэмжээг бодитой тодорхойлж, хэрэгжилтийг хангах.
- ✓ Гүйцэтгэлийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгох.

- ✓ ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын зориулалтыг өөрчилж гэрээ байгуулахгүй байх.

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Энхбаяр танаа

- ✓ Хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгүүдийн баримт бичгийг бүрдүүлж, хөрөнгө бүртгэх шийдвэр гаргуулах.

ГХБХБГ -ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Шинэзориг танаа

- ✓ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа нийтийн орон сууцны барилгын ажлыг зураг төсвийн дагуу иж бүрэн хянаж, гадна тохижилтын ажил дутуу байхад байнгын ашиглалтад хүлээн авахгүй байх.

Жаргалант сумын Засаг дарга Б.Амартүвшин танаа

- ✓ ХАА-г хуулийн дагуу зохион байгуулж, 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ-ний гүйцэтгэлийн баталгааг хангуулж гэрээг байгуулах.
- ✓ Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах.

Жаргалант сумын ИТХ-ын Х.Батсүрэн танаа

- ✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгийн зардлыг төлөвлөж, урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх.

Цэцэг сумын Засаг дарга Б.Баярсайхан танаа

- ✓ Хөрөнгө оруулалтын ТАХ хөгжлийн төлөвлөгөө болон хууль журамд нийцүүлэн төлөвлөх.

Цэцэг сумын ИТХ-ын дарга Г.Гантулга танаа

- ✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгийн зардлыг төлөвлөж, урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн ЗДТГ-ын СТСХ, БОНХОХБТХ, ГХБХБГ-ын хамт олонд талархал илэрхийлье.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР